



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/02/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.gov.mn](#)

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [g.gunzhidmaag@audit.gov.mn](mailto:g.gunzhidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [d.enekhimegd@audit.gov.mn](mailto:d.enekhimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: [d.tserenkhandd@audit.gov.mn](mailto:d.tserenkhandd@audit.gov.mn)



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.06 № 22

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын дансаар дамжуулан Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн салбарын 80 албан хаагчдад орон нутгийн төсвөөс 800,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон аймгийн Засаг даргын захирамжаар Эрүүл эрчимт аяныг зохион байгуулсан байна.

### Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн газарт Мэргэжлийн нялалтын газраас 4 албан хаагчийг шилжүүлэн томилж, 32,699.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст орлого авсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 4 арга хэмжээг 30.0-50.0 хувиар, 4 арга хэмжээг 60.0-70.0 хувиар, 22 арга хэмжээг 80.0-90.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Аймгийн Засаг даргаас 91.4 хувиар үнэлсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд шувший баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд ЭДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Т.ГҮРХИДМАА

<b>Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</b>		<b>/мян.төг/</b>	
Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31	
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,132,722.14	1,362,887.30	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,298,514.38	1,389,803.63	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,431,236.51</b>	<b>2,752,690.93</b>	
Нийт өр төлөөрийн дүн			
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,431,236.51	2,752,690.93	
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,431,236.51</b>	<b>2,752,690.93</b>	
Үйл ажиллагааны орлогын дүн	4,364,887.8	4,919,108.3	
Үйл ажиллагааны зардлын дүн	4,253,155.3	4,594,115.9	
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>111,648.5</b>	<b>321,454.4</b>	
Үйл ажиллагааны бус үр дүн			
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>111,648.5</b>	<b>321,454.4</b>	
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,319,588.0	2,431,236.5	
Тайлант оны үр дүн	111,648.5	321,454.4	
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,431,236.5</b>	<b>2,752,690.9</b>	
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,416,736.7	3,649,646.8	
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,400,062.8	3,802,962.1	
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>18,673.9</b>	<b>46,684.7</b>	
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(18,673.9)</b>	<b>(46,684.7)</b>	
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>			
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,093,258.2</b>	<b>2,537,684.4</b>	
Урсгал зардал	2,074,584.3	2,490,999.7	
Хөрөнгийн зардал	18,673.9	46,684.7	
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>2,093,258.2</b>	<b>2,537,684.4</b>	
Улсын төсвөөс санхүүжих	2,093,258.2	2,537,684.4	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			

### **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Залруулагдаагүй нийт 22.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 22.2 сая төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрсэнд алба шаардлага хүргүүлсэн.

### **Төлбөрийн акт**

1. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл 1.3 сая төгрөгийг 1 ажилтанд дутуу олгосон нь Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоол 4-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон цалин 1.3 сая төгрөгийг буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

2. Эм боох материалын нөөцөөс 0.7 сая төгрөгийг шаардахар зарцуулсан на Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бус зарцуулсан 0.7 сая төгрөгийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Албан хаагчдад 12 сард нэмж хоолны хөнгөлөлт 20.0 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны хөнгөлөлтийг бөөн дүнгээр олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газрын	3	22.2	2	2.05	1	20.2	-	-	-	-	-	-
Дүн	3	22.2	2	2.05	1	20.2	-	-	-	-	-	-

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийсэн	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ		1			1				
	НИЙТ		1			1				